

“МОНГОЛЫН ТӨМӨР ЗАМ” ТӨХК-ИЙН ХАРААТ БУС ГИШҮҮНИЙ СУЛ ОРОН ТООН ДЭЭР СОНГОН ШАЛГАРУУЛАЛТЫГ НЭЭЛТТЭЙ ЯВУУЛСАН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ

“Монголын төмөр зам” ТӨХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл нийт 9 гишүүнтэй, үүнээс төрийн төлөөллийн 6 гишүүн, хараат бус 3 гишүүн тус тус Хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгч ТӨБЗГ-ын тогтоолоор томилогдон ажиллаж байна. 2024 онд компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус 1 гишүүний хугацаа дууссан тул уг орон тоон дээр нээлттэй сонгон шалгаруулалт зарласан.

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2024 оны 03 сарын 19-ний өдрийн А-1/581 дугаар удирдамж, Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 85 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Төрийн өмчит компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүнийг сонгон шалгаруулах журам”-ын дагуу сонгон шалгаруулалтыг зохион байгуулсан. Төлөөлөн удирдах зөвлөл хуралдаж хараат бус гишүүний сонгон шалгаруулалтыг зохион байгуулах Нэр дэвшүүлэх түр хороог байгуулж, ““Монголын төмөр зам” ТӨХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүнд нэр дэвшигчид тавигдах шаардлага, бүрдүүлэх баримт бичгийн жагсаалт”-ыг 2024 оны 04 дүгээр сарын 05-ны өдрийн хурлаар баталсан. Ингээд Нэр дэвшүүлэх түр хороо “Монголын төмөр зам” ТӨХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус 1 гишүүний сул орон тоон дээр сонгон шалгаруулалтыг зарлан зохион байгуулж, нэр дэвшигчдийн материалыг 2024 оны 04 дүгээр сарын 08-ны өдрөөс 2024 оны 04 дүгээр сарын 12-ны өдрийн 17.00 цаг хүртэл хүлээн авсан. Сонгон шалгаруулалтад нийт 4 нэр дэвшигч материалаа ирүүлснээс журмын дагуу баримт бичгийн бүрдэл болон нийтлэг, тусгай шаардлагыг хангасан байдлыг хянан үзэж, нэгдсэн оноог гаргаж, хамгийн өндөр оноо авсан нэр дэвшигч Д.Нар-Од (28 оноо)-ыг Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүнээр томилуулахаар холбогдох материалыг Хувьцаа эзэмшигчид хүргүүлэн шийдвэрлүүлсэн.

"Монголын төмөр зам" ТӨХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн
хараат бус гишүүнд нэр дэвшигчдийг үнэлэх нэгдсэн үнэлгээний жагсаалт

д/д	Хараат бус гишүүнд нэр дэвшигчийн овог нэр	I шат	II шат		Нийт оноо	Шалгаруулал тад тэнцсэн эсэх /тийм, үгүй/
		Баримт бичгийн бүрдэлт	Ерөнхий шаардлага	Тусгай шаардлага		
1	Д.Нар-Од	10	15	3	28	Тийм
2	Б.Ууганхүү	9	15	1	25	Үгүй
3	Ё.Байгалмаа	9	14	-	23	Үгүй
4	З.Ядмаа	8	-	-	8	Үгүй